



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/193

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэзсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1-ийн "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 45 дугаар тогтоолоор батлагдсан "Коронавируст халдвар /ковид-19/-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам"-ын хэрэгжилтийг хангах, иргэдийн болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зогсоох зорилгоор "Хэнтий аймгийн төв Чингис хотыг бүсчлэн хаах төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангах, хяналтын 11 постыг энэ оны 05 дугаар сарын 08-ны 06:00 цаг хүртэл сунгасан тул 13 хоногийн хугацаанд ажиллах 22 алба хаагчийн хоол, автомашины шатах тослох материал болон "Шуурхай штаб", "Тусгаарлах байр"-нд үүрэг гүйцэтгэж буй 7 алба хаагчдын хоолны зардлыг хавсралтаар тус тус баталсугай.

2. Урьдчилан сэргийлэх, халдварын тархалтын түвшинг тогтооход шаардагдах 9.906.500 /есөн сая есөн зуун зургаан мянга таван зуу/ төгрөгийг аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011243

Аймгийн Засаг даргын 2021 оны
04 дугаар сарын 24 өдрийн
дугаар захирамжийн хавсралт



Зардлын тооцоо

Байгууллагын нэр	Зардлын төрөл				Дүн
	Шатахууны зардал	Шуурхай штаб	Хоолны зардал	Тусгаарлах байрны түлш, хоол	
Цагдаагийн газар	2.216.500		5.720.000	150.000	8.086.500
Онцгой байдлын газар		1.300.000		520.000	1.820.000
ДҮН	2.216.500	1.300.000	5.720.000	670.000	9.906.500